



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

“ШУТИС-ийн суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журам” батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12.1.4, ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Н.Ганзориг), Оюутны соёл, үйлчилгээний албаны дарга (Н.Санчирбаатар), бүрэлдэхүүн, харьяа сургуулиудын захирлуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Захирлын 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/86 дугаар тушаалаар батлагдсан “Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”, 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/223 дугаар тушаалаар баталсан “ШУТИС-ийн оюутнуудад кредит урамшуулал олгох журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү журмыг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.


ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.НАМНАН

367040706



	Суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журам ШУТИС-ОУ-ЖУ02	Эхний хэвлэлт	2016.06.10
		Өөрчилсөн огноо	2022.04.13
		Өөрчлөлтийн дугаар	1

ШУТИС-ийн СУРАЛЦАГЧДАД ТЭТГЭЛЭГ, КРЕДИТИЙН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Боловсруулсан:

Оюутны соёл, үйлчилгээний алба

Хянасан:

Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал
 Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний алба

Дэмжсэн:

ШУТИС-ийн Захирлын зөвлөл

Баталсан:

ШУТИС-ийн Захирал



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
A/136 дугаар тушаалын хавсралт

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ.....	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	3
ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	3
ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАРУУЛАХ.....	4
ДОЛОО. БУСАД	8
ХАВСРАЛТ 1. ТЭТГЭЛЭГ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ.....	9
ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ.....	10-11



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 ШУТИС-ийн суралцагчдын сурч боловсрох, нийгмийн идэвх оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг дэмжих зорилгоор тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох үйл ажиллагааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 ШУТИС-ийн тэтгэлэг, кредитийн урамшуулалд хамрагдахыг хүссэн ШУТИС-Коосэн технологийн коллеж, бакалавр, магистр, докторт суралцагчид хамрагдана.
- 2.2 Тус журам нь тэтгэлэг, кредитийн урамшуулал авах болзол хангасан суралцагчийн материал хүлээн авах, шалгаруулах, олгох үйл явцыг хамарна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1 Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч суралцагчийн тэтгэлэг олгох журам (2014);
- 3.2 Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль (2011);

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 **Тэтгэлэг:** ШУТИС-ийн суралцагчдад сургалтын төлбөр болон бусад төлбөрөөс чөлөөлөх хэлбэрээр олгогддог санхүүгийн дэмжлэг;
- 4.2 **Кредитийн урамшуулал:** Сурлагын болон эрдэм шинжилгээ, урлаг, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, амжилт гаргасан суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт хэлбэрээр үзүүлдэг санхүүгийн дэмжлэг;
- 4.3 **Тэтгэлгийн комисс:** Тэтгэлэг олгох үйл ажиллагааг хэлэлцэн шийдвэрлэх чиг үүрэг бүхий, сургалт, оюутны асуудал хариуцсан захиргааны нэгжээс 3, санхүүгийн асуудал хариуцсан захиргааны нэгжээс 1, ШУТИС-ийн Оюутны холбооноос 1, нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс.

ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1 ШУТИС-ийн Захирал нь тэтгэлэг, урамшууллын хэмжээ болон тэтгэлгийн комиссыг тушаалаар баталгаажуулна.
- 5.2 Оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгж:
 - 5.2.1 Бүрэлдэхүүн сургуулиас ирүүлсэн тэтгэлэг, кредитийн урамшуулалд нэр дэвшигчийн материалыг шалгаж, хүлээн авах;
 - 5.2.2 Тэтгэлэг, кредитийн урамшуулал авах суралцагчийн тушаал боловсруулж, батлуулах;
 - 5.2.3 Тэтгэлгийн комисс байгуулах тушаалын төслийг боловсруулж, батлуулах;
 - 5.2.4 Тэтгэлгийн комисст нэр дэвшигчийн материалыг хүргүүлж, шалгаруулах ажлыг зохион байгуулах;
 - 5.2.5 Шалгарсан суралцагчид мэдээлэл хүргэж, тэтгэлэг, кредитийн урамшууллыг олгох, гардуулах ажлыг зохион байгуулах;



- 5.2.6 Тэтгэлэг, кредитийн урамшуулалтай холбоотой мэдээллийн сан үүсгэх, баримт бичгийг хадгалах, тайлан мэдээ гаргах.
- 5.3 Бүрэлдэхүүн сургууль:
- 5.3.1 Тэтгэлэг, кредитийн урамшуулал зарлах, мэдээлэх, зөвлөгөө өгөх;
 - 5.3.2 Тэтгэлэгт нэр дэвшигчийн материалыг шалгаж, хүлээн авах;
 - 5.3.3 Кредитийн урамшуулалд нэр дэвшигчийг сургалтын мэдээллийн сангаас шүүж, тодруулах;
 - 5.3.4 Сургуулийн захирлын зөвлөлөөр тэтгэлэг, кредитийн урамшуулалд нэр дэвшигчийн материалыг хэлэлцүүлж шилдэг суралцагчаас бусад шаардлага хангасан материалыг оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгжид хүргүүлэх;
 - 5.3.5 Сургуулийн захирлын зөвлөл тухайн хичээлийн жилийн хавар, намрын улиралд 3.6-аас дээш голч дүн бүхий бакалаврт суралцагчийн жагсаалтыг гаргаж тухайн улиралд 100 хүртэлх суралцагчид энэхүү журмын 6.4.5 дахь заалтын дагуу кредитийн урамшуулал олгоно.
 - 5.3.6 Шилдэг суралцагчийн кредитийн урамшууллын тушаалыг хичээлийн жилийн улирал бүрийн хичээл сонголт хоёроос өмнө бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулж гаргасан байна.
 - 5.3.7 Шаардлага хангаагүй материалыг буцааж, нэр дэвшигчид мэдээлнэ.
- 5.4 ШУТИС-ийн Оюутны холбоо:
- 5.4.1 Бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөл, байрны зөвлөлийн үйл ажиллагааны тайланг дүгнэх;
 - 5.4.2 Оюутны холбооны нэгтгэсэн тайланг кредит урамшуулалд нэр дэвшигчийн материалын хамт ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн, оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгжид жилд 2 удаа хүргүүлэх;
- 5.5 Тэтгэлэгийн комисс:
- 5.5.1 Тэтгэлэгт нэр дэвшигчийг сонгон шалгаруулах;
 - 5.5.2 Тэтгэлэгт шалгарсан суралцагчдын нэрийг баталгаажуулж, оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгжид хүлээлгэн өгөх;
- 5.6 Суралцагч /нэр дэвшигч/:
- 5.6.1 Тэтгэлэг, кредитийн урамшуулалд тавигдах шаардлагын дагуу материал бүрдүүлж, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд хүргүүлэх;
- 5.7 Кредитийн урамшуулал авах болзол хангасан соёл, урлагийн тэмцээн уралдаанд амжилт гаргасан суралцагчийн материалыг “ШУТИС-ийн Залуус” чуулга, спортын тэмцээн, уралдаанд амжилт гаргасан суралцагчийн материалыг ШУТИС-ийн Биеийн тамирын тэнхим тус тус тодорхойлж оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ.

ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ, ШАЛГАРУУЛАХ

- 6.1 Тэтгэлэгт нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- 6.1.1 Суралцагчийн дүнгийн жагсаалт (улирлаар хэвлэж, Сургалтын алба баталгаажуулах)



- 6.1.2 Оюутны анкет (цахимаар бөглөх)
- 6.1.3 Бүрэлдэхүүн, харьяа сургуулийн захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл
- 6.1.4 Амжилт гаргасныг нотлох бичиг баримтын хуулбар
- 6.2 Бүрэлдэхүүн сургууль тэтгэлэг, кредитийн урамшууллын болзол хангасан элсэгч, суралцагч, төгсөгчийн материалыг хичээлийн жилд 2 удаа хүлээн авч, шалгаруулна.
- 6.3 ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэгт бүрэлдэхүүн сургууль бүрээс жилд 5 хүртэлх суралцагчийг тодорхойлж, ШУТИС-ийн хэмжээнд жилд 50 хүртэлх суралцагчийг шалгаруулан хамруулна.
- 6.4 Тэтгэлэг, кредитийн урамшууллыг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд олгоно. Үүнд:

№	Төрөл	Шалгуур үзүүлэлт	Тэтгэлэг, урамшууллын хэмжээ
ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг			
6.4.1	Элсэгч	<ul style="list-style-type: none"> “ШУТИС-ийн суралцагч элсүүлэх журам”-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан элсэгч байна. 	<ul style="list-style-type: none"> “ШУТИС-ийн суралцагч элсүүлэх журам”-д заасан урамшуулал, хөнгөлөлт
6.4.2	Суралцагч (бакалавр,-магистр, доктор)	<ul style="list-style-type: none"> Үнэлгээний голч дүн 3.6 ба түүнээс дээш байх; Олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд амжилттай оролцож эхний гурван байранд шалгарсан; Оюутны эрдэм шинжилгээний ажил, олимпиадад амжилттай оролцож эхний гурван байрт шалгарсан; Сайн дурын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон; <p>Дээрх дөрвөн шалгуур үзүүлэлтийн 3-ыг зайлшгүй хангасан суралцагч байна.</p>	<ul style="list-style-type: none"> Тухайн хичээлийн жилд 30 хүртэл кредит (Бакалавр) Тухайн хичээлийн жилд 15 хүртэл кредит (Магистр, доктор)
6.4.3	Шилдэг, тэргүүний төгсөгч	<ul style="list-style-type: none"> Үнэлгээний голч дүн 3.2 ба түүнээс дээш дүнтэй суралцсан; Эрдэм шинжилгээ, сурлага, урлаг, спортоор ШУТИС болон улсын хэмжээнд амжилт гаргасан; Шинэ санаа, үр дүнг хэвлэн нийтлүүлсэн техник технологийн ололт амжилтыг хэрэглээнд нэвтрүүлсэн; Сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд тогтмол үр дүнтэй оролцож, зохион байгуулсан; <p>Дээрх дөрвөн шалгуур үзүүлэлтийн 3-ыг зайлшгүй хангасан төгсөгч байна.</p>	<ul style="list-style-type: none"> 1.5 кредит хүртэл мөнгөн шагнал



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
А/136 дугаар тушаалын хавсралт

6.4.4	Суралцагч (ШУТИС-Коосэн технологийн коллеж)	<ul style="list-style-type: none"> Олон улсын болон улсын чанартай олимпиадад амжилттай оролцож эхний гурван байр эзэлсэн суралцагч; 	<ul style="list-style-type: none"> Тухайн хичээлийн жилд сургалтын төлбөрийн 100 хүртэл хувь
		<ul style="list-style-type: none"> Улсын чанартай олимпиадын хоёрын даваанд амжилттай оролцож шагналт байрт шалгарсан; 3.2 ба түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй 2 улирал дараалан суралцсан, санхүүгийн хувьд дэмжлэг авах шаардлагатай; 	<ul style="list-style-type: none"> Тухайн хичээлийн жилд сургалтын төлбөрийн 50 хүртэл хувь
Кредитийн урамшуулал:			
6.4.5	Шилдэг суралцагч (бакалавр)	<ul style="list-style-type: none"> Тухайн хичээлийн улиралд 15-аас доошгүй кредит сонгон 3,6 буюу түүнээс дээш үнэлгээний голч дүнтэй суралцаж, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар дэмжигдсэн бакалаврын сургалтад суралцагч 	<ul style="list-style-type: none"> Хичээлийн улиралд 1 кр
6.4.6	Эрдэм шинжилгээний хурал, олимпиадад амжилт гаргасан суралцагч	<ul style="list-style-type: none"> Бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээний хурал, олимпиадад эхний гурван байрт шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 1 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн хэмжээнд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиадад эхний гурван байрт шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 2 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Улсын чанартай эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиадад эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 3 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Олон улсын эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиадад эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 4 кр хүртэл
6.4.7	Мэргэжлийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан суралцагч	<ul style="list-style-type: none"> Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд зохиогдсон уралдаан, тэмцээнд эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 1 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн уралдаан, тэмцээнд эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 2 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Улсын чанартай уралдаан, тэмцээнд эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 3 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Олон улсын хэмжээний уралдаан, тэмцээнд эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 4 кр хүртэл



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
113 дугаар тушаалын хавсралт

6.4.8	Спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан суралцагч	<ul style="list-style-type: none"> Хот /нийслэл/-ын аварга шалгаруулах тэмцээн, их, дээд сургуулиудын суралцагчдын дундах тэмцээнд эхний гурван байранд шалгарсан суралцагч Улсын чанартай тэмцээн, лигийн тэмцээнд эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 2 кр хүртэл 3 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Олон улсын чанартай тэмцээнд эхний гурван байрт шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 4 кр хүртэл
6.4.9	Соёл, урлагийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан суралцагч	<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн урлагийн их наадамд эхний гурван байрт шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 2 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Улсын уралдаан, тэмцээнд эхний гурван байранд шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 3 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Олон улсын соёл, урлагийн уралдаан, тэмцээнд эхний гурван байрт шалгарсан суралцагч 	<ul style="list-style-type: none"> 4 кр хүртэл
6.4.10	Тухайн улиралд 15-аас доошгүй кредит сонгон, 2.5 үнэлгээний голч дүнтэй суралцсан оюутны холбоо, зөвлөл, клуб, олон нийтийн үйл ажиллагаанд амжилт гаргасан суралцагч	<ul style="list-style-type: none"> Хичээлийн бус цагаар өөрийн сурсан мэдсэнийг бусадтайгаа хуваалцан клубт хичээл заадаг суралцагчид 	<ul style="list-style-type: none"> 3 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Нийгэм олон нийтийн нэгдсэн арга хэмжээнд клуб хамт олноо зохион байгуулан оролцдог клубийн ахлагч 	<ul style="list-style-type: none"> 2 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Клуб олон нийтийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай тогтмол оролцдог клубийн гишүүн 	<ul style="list-style-type: none"> 1 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн 	<ul style="list-style-type: none"> 12 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн Оюутны холбооны дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн дарга, клубийн нэгдсэн зөвлөлийн дарга, хяналтын хорооны дарга, гишүүд (8 хүртэлх суралцагчид) 	<ul style="list-style-type: none"> 8 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөлийн дарга 	<ul style="list-style-type: none"> 6 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөлийн гишүүн (4 хүртэлх суралцагч) 	<ul style="list-style-type: none"> 3 кр хүртэл
		<ul style="list-style-type: none"> Оюутны байрны зөвлөлийн дарга 	<ul style="list-style-type: none"> 4 кр хүртэл
<ul style="list-style-type: none"> Оюутны байрны зөвлөлийн гишүүд (4 хүртэлх суралцагч) 	<ul style="list-style-type: none"> 2 кр хүртэл 		



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
А/136 дугаар тушаалын хавсралт

ДОЛОО. БУСАД

- 7.1 ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэгт шалгарсан суралцагчдын нэрийг ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулж, өргөмжлөлийг хичээлийн жилийн нээлт, төгсөлтийн ёслолын ажиллагааны үеэр гардуулна.
- 7.2 Шилдэг суралцагчаас бусад кредитийн урамшуулалд шалгарсан суралцагчдын кредитийн урамшууллыг хичээлийн жилийн улирал бүрийн хичээл сонголт 2-оос өмнө ШУТИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж, сургалтын төлбөрт шилжүүлэн олгоно.
- 7.3 Их сургуулийн холбогдох нэгжүүд олон улсын болон гадаад, дотоодын байгууллага, хувь иргэний нэрэмжит тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг тухайн тэтгэлэгт тавигдах шаардлага, журмын дагуу хамтран зохион байгуулж болно. Мөн энэхүү тэтгэлгийг ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэгтэй нэгтгэн, хамрагдах суралцагчдын тоог нэмэгдүүлэн олгохыг зөвшөөрнө.
- 7.4 Цар тахал, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосноос шалтгаалан тухайн улиралд сургалтын үйл ажиллагаа цахим болон танхим, цахим хослон явагдсан тохиолдолд кредитийн урамшуулал олгохгүй.
- 7.5 Магистр, докторантурт суралцагчдад 6.4.5 дахь заалтын дагуу кредитийн урамшуулал олгохгүй.
- 7.6 Тэмцээн, уралдааны нэр төрөл, журмын заалт давхцуулан кредитийн урамшуулал олгохгүй. (Хамтарсан илтгэл, өгүүлэл, мэргэжлийн уралдаан тэмцээнд багаараа оролцсон тохиолдолд багийн гишүүн тус бүрд кредитийн урамшуулал олгоно)

---oOo---



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
А/136 дугаар тушаалын хавсралт

ХАВСРАЛТ 1. ТЭТГЭЛЭГ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: **[R]** - Хариуцан хийж, гүйцэтгэх; **[A]** - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; **[C]** - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; **[I]** – Алхмын гаралтыг мэдээлэх

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо			
				НД	Б С	ОС ҮХН	Т К
1	Сургалтын нэгдсэн хуанли	1. Тэтгэлэг, урамшууллыг зарлах	Зарлал	I	R	A	
2	Зарлал, шалгуур үзүүлэлт	2. Материал бүрдүүлэх	Суралцагчийн анкет, баримт нотолгоо	R/A	C		
3	Суралцагчийн анкет, баримт нотолгоо	3. Нэр дэвшигчийн материал хүлээн авч, шалгаруулалтад бэлтгэх	Нэр дэвшигчдийн материал	C	R/A		
4	Нэр дэвшигчийн материал	4. Анхан шатны шалгаруулалт хийх Шаардлага хангасан эсэх Тийм Үгүй	Анхан шатнаас шалгарсан материал, нэрс	I	R/A		
5	Анхан шатнаас шалгарсан материал, <u>Маягт ОУ-М001, ОУ-М002</u>	5. Эцсийн шалгаруулалт хийх Шаардлага хангасан эсэх Тийм Үгүй → 5а. Нэр дэвшигчийг хасах	Сургуулиудын шалгарсан материал, нэрс ОУ-М003	I	C	A	R
6	Сургуулиудын шалгарсан материал, нэрс	6. Захирлын тушаал гаргуулах	ШУТИС-ийн захирлын тушаал	I	I	R/A	
7	ШУТИС-ийн захирлын тушаал	7. Тэтгэлэг, урамшууллыг олгох	Олгосон тэтгэлэг, урамшуулал	C	I	R	

*НД- нэр дэвшигч

*БС- Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба, захирлын зөвлөл

*ОСҮХН- Оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгж

*ТК- тэтгэлгийн комисс



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
А/136 дугаар тушаалын хавсралт

ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ МАЯГТ

№	Маягтын нэр	Маягтын дугаар код	Хадгалах эзэн/байршил
1	Кредитийн урамшуулалд нэр дэвшигч болоод шалгарсан бүртгэл	OY-M001	Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба
2	Тэтгэлэгт нэр дэвшигч болоод шалгарсан суралцагчийн бүртгэл	OY-M002	Оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгж
3	Тэтгэлэгт нэр дэвшигчийг шалгаруулах үнэлгээний хуудас	OY-M003	Оюутны соёл, үйлчилгээ хариуцсан нэгж

Маягт: OY-M001

Кредитийн урамшуулалд нэр дэвшигчийн бүртгэл

№	Нэр	Сургууль	Салбар тэнхим	Дамжаа	Сур.код	Гаргасан амжилт	Олгогдох кредит	Авсан оноо	Тушаалын огноо	Шалгарсан эсэх	Шалгараагүй бол шалтгаан
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Маягт: OY-M002

Тэтгэлэгт нэр дэвшигчийн бүртгэл

№	Эцэг /хүийн нэр	Нэр	Регистр	Хүйс	Сургууль	Салбар тэнхим	Мэргэжил	Сур.код	Голч дүн /GPA	Нийт кредит	Ам бул	E-mail	Гар утас	Өрхийн дундаж орлого	Хаана амьдардаг	Гэрийн хаяг	Сургалт дэдлага	Авъяас чадвар	Нийгэм ОНБ-ын үйл ажиллагаанд оролцсон байдал	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээл	Шагнал	Комиссын гишүүдээс санал авсан эсэх	Шалгарсан эсэх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24



ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн
А/136 дугаар тушаалын хавсралт

Маягт: ОУ-M003

Тэтгэлэгт нэр дэвшигчийг шалгаруулах үнэлгээний хуудас

№	Оюутны нэрс	Сургууль	Шалгуур үзүүлэлтийн оноо (0-4)	Комиссын гишүүдийн оноо (0-4)	Нийт оноо
1.					